



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2024.10.21 № 22

Геологи, хайгуулын салбарт
баримтлах бодлого, төлөвлөлт,
бүтцийн өөрчлөлт хийх талаар

Геологи, хайгуулын салбарын эрдэмтэд, судлаачид, ахмад геологичид, салбарын төрийн бус байгууллагуудаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны зүгээс Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Үндэсний геологийн албыг татан буулгаж, Газрын тосны газар байгуулах ажлыг зохион байгуулж байгаа нь буруу, геологийн салбарын тогтолцоог буцаагаад нураах нь буруу гэсэн санал, гомдлыг удаа дараа ирүүлсээр байна.

Монгол төрийн бодлогын хүрээнд нийгэм, эдийн засгийн хөгжил, үндэсний аюулгүй байдал, түүн дотроо газар нутгийн бүрэн бүтэн байдал, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад геологийн салбар чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ ч утгаараа "Алсын хараа 2050" урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны "Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно" гэсэн зорилтын хүрээнд эдийн засгийн өсөлтийг хангах эрдэс баялагийн нөөцийг нэмэгдүүлнэ" гэжээ.

Түүнчлэн Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын хүрээнд хилийн бүс болон Монгол орны газар нутгийн геологи ашигт малтмалын судалгааг хийх, улсын эдийн засгийн аюулгүй байдлын хүрээнд ашигт малтмалын эрэл хайгуул явуулах, улсын хот төлөвлөлт, зам, дэд бүтцийн салбарыг дэмжих ажлын хүрээнд инженер геологийн судалгаа, хүн ам, хүрээлэн буй орчны аюулгүй байдлын хүрээнд газар хөдлөл, үер ус, хөрсний бохирдол зэрэг олон салбар дундын асуудлуудыг геологийн салбар шийдвэрлэдэг байхад том чиг үүрэг бүхий байгууллага болох Үндэсний геологийн албыг татан буулгаж хамрах асуудлын ач холбогдлыг бууруулах зайлшгүй шаардлага байгаа эсэх талаар тодруулах, салбарын сайдын байр суурийг сонсох нь зүйтэй гэж үзлээ.

Геологи, хайгуулын салбарын бодлогыг хэрэгжүүлэх бүтцийг зөв болгож хөгжүүлэх асуудал олон жил яригдаж, 2014 онд Ашигт малтмалын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр эрх зүйн орчин нь бүрдсэн боловч ямар нэг шалтгаанаар хэрэгжилт хангагдахгүй явсаар Улсын Их Хурал, Засгийн газраас Үндэсний геологийн албыг 2020 онд байгуулаад удаагүй байна. Өмнө нь геологи, уул уурхайн салбарыг нэгтгэсэн бүтэц бүхий төрийн захиргааны байгууллага буюу Ашигт малтмалын газар ажиллаж байсан. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд явж ирсэн тогтолцоог дүгнэхэд геологи, хайгуулын салбарын хөгжилд дэмжлэг

2024000047

болохуйц бүтэц зохион байгуулалт байж чадаагүй. Захиргааны бүтэц талаас нь явцуу байдлаар хандаж ирсэн байна. Геологи, уул уурхайн салбарууд нь өөр, өөрийн нарийн мэргэжлийн чиг үүрэг бүхий төрийн захиргааны байгууллагууд болон хөгжих шаардлагатай байна.

Иймд, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

1. Геологи, хайгуулын салбарын өнөөгийн удирдлага, зохион байгуулалтын нөхцөл байдал, судалгааны түвшин, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар;

2. Геологи, хайгуулын салбарын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулж, шийдвэрлэх, хүрэх үр дүнгийн талаар;

3. Үндэсний геологийн албыг ямар үндэслэлээр татан буулгах асуудлыг хөндөж байгаа талаар;

4. Үндэсний геологийн албыг татан буулгах, нэгтгэх, нийлүүлэх зэргээр бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийхдээ гадаадын улс орнуудад геологи, хайгуулын төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг бүтцийн талаар судалсан эсэх, өөрийн улс орны нөхцөл байдал, бодлого зорилттой харьцуулж судлан дүн шинжилгээ хийсэн эсэх талаар;

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

The image shows a red rectangular official stamp of the State Great Khural of Mongolia. The stamp contains the text 'МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН' at the top and 'УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН' at the bottom. A blue ink signature is written across the stamp, extending from the left side towards the right. The signature appears to be 'С. ГАНБААТАР'.

С.ГАНБААТАР

2024000044